



Хоёр хувь хэвлэж багш болон үнэлгээний баг ашиглана.

САНАМЖ

- Сорил гүйцэтгүүлэхийн өмнө зам, талбай, орчны аюулгүй байдлыг сайтар хангаарай.
- Сорил гүйцэтгэх хүүхдээр бие халаалтын дасгал, хөдөлгөөнийг заавал хийлгээрэй.
- Сорил гүйцэтгэхэд хүүхдэд өөрт нь тохиромжтой, гутал, хувцас, хөдөлгөөн, эрүүл мэндийн сургалт, үйл ажиллагааны үед өмсдөг хувцсыг нь өмсүүлээрэй.
- Биеийн тамирын багш, үнэлгээний багийн гишүүд сорилыг гүйцэтгүүлэхийн өмнө хүүхдэд биечлэн хийж үзүүлээрэй.
- Сорилыг бүрийг аргачлалын дагуу гүйцэтгүүлээрэй.
- Сорил гүйцэтгэсэн хүүхэд бүрийн гүйцэтгэлийн үзүүлэлтийг сорилын гүйцэтгэлийг тэмдэглэх хүснэгтэд бичээрэй.

1. Сорил 1. Авхаалж самбаа:

Хүүхдийн авхаалж самбаатай чанарыг хэмжихдээ тодорхой зайнаас сагсанд шидэж оруулсан бөмбөгний тоогоор тооцно.

Хэрэглэгдэхүүн: Шидэлтийн зураас тэмдэглэх шохой, даавуун лент, шидэлтийн зайг хэмжих метр, 15 сантиметрын диаметртэй бөмбөг 5 ширхэг, 40-50 сантиметр өндөртэй, 30 сантиметрийн диаметртэй 1 ширхэг сагс

Аргачлал:

- Бага бүлэг 1 метр зайнаас шидэлтийн зураасны ард өлмийг хүргэж чөлөөтэй зогсож, 5 ширхэг бөмбөг тус бүрийг хоёр гараар доороос шидэж сагсанд оруулна.
- Сагсанд оруулсан бөмбөгний тоогоор амжилтыг тэмдэглэнэ. Жишээ: 4 бөмбөг

2. Сорил 2. Тэнцвэр:

Бага бүлэг: Нэг хөл дээр зогсох зогсолтоор тэнцвэрээ хадгалж зогссон хугацааг тэмдэглэнэ.

Хэрэглэгдэхүүн: Хугацаа хэмжигч

Аргачлал: 1-ээс 3 хүүхэд талбайн голд бие биедээ саад болохгүй чөлөөтэй байрлаж зогсоно. Багш хөлөө өргөөрэй дохиогоор баруун эсвэл зүүн хөлөө өргөн /аль нэг хөлөө газраас хөндийрүүлсэн/ тэнцвэрээ хадгалан /зогсоно. Багш хүүхэд бүрийг ажиглана. Нэг хөл дээрээ зогссон хугацааг секундээр тэмдэглэнэ.

Аюулгүй байдал:

- Тэнцвэрээ хадгалж зогсоход бие биедээ хүрч болохгүй
- Хүүхдийн анхаарал төвлөрөлтөнд саад хийж болохгүй
- Хүүхдүүд хоорондоо ярьж болохгүй

Хүүхдийн цэцэрлэгийн биеийн тамирын багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээнд ашиглах сорилын матриц

Бүлэг	Чанар				
	Хурд	Хүч	Уян хатан	Авхаалж самбаа	Тэнцвэр
Бага				+	+